



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/120.

Мандалговь

Малчин өрхүүдэд тусламжийн хүнсний  
бараа хүргэх ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А-48 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл (нэмэлт санхүүжилт) -ийн хүрээнд тусламжийн хүнсний барааг олгох малчин өрхийн тоог тогтоосон жагсаалтыг 1 дүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусламжийн хүнсний барааг сонгогдсон малчин өрхөд хүргэх ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулж тайланг Хүнс хөдөө аж ахуйн газарт 03 дугаар сарын 23-ны дотор хүргүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тусламжийн хүнсний барааг малчин өрхөд хүргэх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож, тайланг Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, төслийн нэгжид хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210328